



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/203/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг
түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.6.3 Нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	15
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	15
4.2.1 Залруулсан алдаа.....	15
4.2.2 Төлбөрийн акт.....	15
4.2.3 Албан шаардлага	15
4.2.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗГ	Засгийн газар

1.Аудитын санал дүгнэлт



СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГА Н.БАЯРМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжилзүйн хэлтэсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Стандарт хэмжил зүйн хэлтэсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцсийн тооллогын 10.9 сая төгрөгийн бараа материал, 152.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1, 20.2.6 дахь заалтууд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын 12, 17 стандартуудын заалттай нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

012021896

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,446.00	14,338.50
33	АВЛАГА	8,432.18	3,430.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	693.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	103.38	-
335	Бусад авлага	8,328.80	2,737.21
3351	Байгууллагаас авах авлага	8,328.80	2,737.21
35	БАРАА МАТЕРИАЛ	9,013.82	10,908.29
351	Түүхий эд материал	301.20	301.20
35110	Тусгай зориулалттай материал	301.20	301.20
354	Хангамжийн материал	8,712.62	10,607.09
35410	Бичиг хэргийн материал	2,837.58	3,612.49
35420	Аж ахуйн материал	5,534.04	6,653.60
35430	Сэлбэг хэрэгсэл	58.50	58.50
35470	Бусад хангамжийн материал	282.50	282.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	62,067.48	61,652.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,067.48	61,652.08
392	Биет хөрөнгө	55,537.48	55,122.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	46,842.86	46,842.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,837.80)	(15,975.11)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,800.00	18,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,800.00)	(18,800.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,682.13	69,752.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,743.40)	(49,924.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,121.14	9,780.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,039.45)	(5,866.16)
39217	Ном	512.00	512.00
393	Биет бус хөрөнгө	6,530.00	6,530.00
39301	Програм хангамж	380.00	380.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(380.00)	(380.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,530.00	6,530.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	79,513.48	75,990.57
413	Өглөг	1,044.50	748.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	748.00
4136	Бусад өглөг	1,044.50	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,044.50	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	79,513.48	75,990.57
51	Засгийн газрын хувь оролцоо	78,468.98	75,242.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	106,739.42	106,739.42
51101	Өмч: - төрийн	106,739.42	106,739.42
512	Хуримтлагдсан үр дүн	(93,665.99)	(96,892.40)
51210	Өмнөх үеийн үр дүн	(93,665.99)	(93,665.99)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,226.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	65,395.55	65,395.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	79,513.48	75,990.57

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	207,775.19	234,203.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,927.69	36,779.09
120	Нийтлэг татварын бус орлого	47,927.69	36,779.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,074.24	36,088.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,074.24	36,088.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,847.50	197,424.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	151,588.20	187,820.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	151,588.20	187,820.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,259.30	9,604.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,259.30	9,604.02
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	202,749.84	236,766.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	202,749.84	236,766.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,293.34	196,034.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,663.35	131,748.55
210101	Үндсэн цалин	129,663.35	90,831.16
210102	Нэмэгдэл	-	31,781.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,135.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,770.03	18,176.36
210201	Тэтгэврийн даатгал	7,385.23	12,850.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,649.38	1,369.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,047.61	1,055.03
210204	Ажилгүйдлийн даатгал	517.07	263.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,170.73	2,637.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,770.03	17,210.16
210301	Гэрэл, цахилгаан	221.72	579.36
210302	Түлш, халаалт	13,242.54	16,320.00
210303	Цэвэр, бохир ус	305.77	310.80
2104	Хангамж, бараа материалын зардал	6,122.24	5,013.95
210401	Бичиг хэрэг	1,158.32	915.68
210402	Тээвэр, шатахуун	3,183.00	1,631.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,199.22	1,819.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	245.40	219.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	318.30	427.00
210408	Бараа материал акталсны зардал	18.00	-
2105	Нормативт зардал	999.97	2,339.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	999.97	840.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,499.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,484.00	803.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	484.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	3.60

210604	Урсгал засвар	3,000.00	799.80
2107	Томилолт, зочны зардал	9,010.30	5,300.00
210702	Дотоод албан томилолт	9,010.30	5,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,348.77	767.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297.00	300.00
210803	Даатгалын үйлчилгээ	56.55	81.68
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44.00	44.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	195.00	93.90
210807	Газрын төлбөр	-	87.43
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48.22	23.74
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	386.00	114.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,124.66	14,675.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,632.17	745.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250.00	784.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,242.50	13,144.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,456.50	40,732.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	600.00	36,834.15
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	34,627.15
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600.00	2,207.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,856.50	3,898.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,856.50	3,898.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,025.35</u>	<u>(2,562.75)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	563.65	663.65
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(563.65)	(663.65)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,461.70</u>	<u>(3,226.40)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	106,739.42	65,395.55	(93,665.99)	78,468.98
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	106,739.42	65,395.55	(93,665.99)	78,468.98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	106,739.42	65,395.55	(93,665.99)	78,468.98
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,226.40)	(3,226.40)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	106,739.42	65,395.55	(96,892.40)	75,242.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	206,628.55	233,615.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,781.05	36,191.47
120	Нийтлэг татварын бус орлого	46,781.05	36,191.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,781.05	36,191.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,781.05	36,191.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,847.50	197,424.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	151,588.20	187,820.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	151,588.20	187,820.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,259.30	9,604.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,259.30	9,604.02
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	206,628.55	229,145.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,628.55	229,145.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	199,172.05	187,940.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,015.47	132,163.21
210101	Үндсэн цалин	95,447.31	90,898.72
210102	Нэмэгдэл	28,934.71	32,128.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,633.45	9,135.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,417.90	17,233.70
210201	Тэтгэврийн даатгал	12,257.10	12,127.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,248.49	1,276.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,073.91	1,021.30
210204	Ажилгүйдлийн даатгал	258.00	255.30
210205	Эрүүл мэндийн даатгал	2,580.40	2,553.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,187.74	17,152.70
210301	Гэрэл, цахилгаан	221.72	521.90
210302	Түлш, халаалт	16,660.25	16,320.00
210303	Цэвэр, бохир ус	305.77	310.80
2104	Хангамж, бараа материалын зардал	7,331.22	6,300.77
210401	Бичиг хэрэг	1,600.00	1,309.54
210402	Тээвэр, шатахуун	3,183.00	1,631.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,199.22	1,819.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	349.00	219.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000.00	1,319.96
2105	Нормативт зардал	1,999.97	840.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	999.97	840.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,758.01	4,337.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,599.41	-

210602	Тавилга	3,659.30	2,737.21
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	499.30	800.00
210604	Урсгал засвар	3,000.00	799.80
2107	Томилолт, зочны зардал	7,999.30	6,275.00
210702	Дотоод албан томилолт	7,999.30	6,275.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,462.77	1,238.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297.00	300.00
210803	Даатгалын үйлчилгээ	56.55	81.68
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44.00	44.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	195.00	179.90
210807	Газрын төлбөр	-	87.43
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48.22	23.74
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500.00	500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,999.67	2,399.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,999.67	1,639.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000.00	759.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,456.50	41,205.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	600.00	37,307.15
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	34,627.15
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600.00	2,680.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,856.50	3,898.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,856.50	3,898.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>4,470.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,470.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,470.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,470.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	4,470.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(4,470.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	222,820.40	229,717.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222,820.40	229,717.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,014.20	192,410.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,436.40	132,163.21
210101	Үндсэн цалин	97,264.40	90,898.72
210102	Нэмэгдэл	30,014.00	32,128.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,158.00	9,135.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,233.70	17,233.70
210201	Тэтгэврийн даатгал	12,127.40	12,127.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,276.60	1,276.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,021.30	1,021.30
210204	Ажилгүйдлийн даатгал	255.30	255.30
210205	Эрүүл мэндийн даатгал	2,553.10	2,553.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,152.70	17,152.70
210301	Гэрэл, цахилгаан	521.90	521.90
210302	Түлш, халаалт	16,320.00	16,320.00
210303	Цэвэр, бохир ус	310.80	310.80
2104	Хангамж, бараа материалын зардал	6,831.30	6,830.77
210401	Бичиг хэрэг	1,310.00	1,309.54
210402	Тээвэр, шатахуун	1,631.40	1,631.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,820.00	1,819.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	219.90	219.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,850.00	1,849.96
2105	Нормативт зардал	840.00	840.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	840.00	840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600.00	8,277.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,940.00
210602	Тавилга	-	2,737.21
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800.00	800.00
210604	Урсгал засвар	800.00	799.80
2107	Томилолт, зочны зардал	6,276.50	6,275.00
210702	Дотоод албан томилолт	6,276.50	6,275.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,243.60	1,238.75
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300.00	300.00
210803	Даатгалын үйлчилгээ	84.10	81.68

210804	Тээврийн хэрэгслийн татвар	44.00	44.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180.00	179.90
210807	Газрын төлбөр	87.50	87.43
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	26.00	23.74
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500.00	500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400.00	2,399.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,640.00	1,639.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	760.00	759.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,806.20	37,307.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,806.20	37,307.15
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,326.20	34,627.15
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480.00	2,680.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	222,820.40	233,615.89
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,820.40	187,820.40
131001	Улсын төсвөөс санхүүжих	187,820.40	187,820.40
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,000.00	36,191.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	36,191.47
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.012	0.012
620001	Удирдах ажилтан	0.001	0.001
620002	Гүйцэтгэх ажилтан	0.008	0.008
620003	Үйлчлэх ажилтан	0.003	0.003

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн №06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс нь стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжилзүйн бодлогоор дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг шуурхай хүргэн, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын баталгаажуулалтад хамруулах, хэмжүүр хэмжих хэрэгслийг улсын ээлжит баталгаажуулалт хийх, үндэсний болон олон улсын стандартыг мэдээлэх, стандартаар ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дээд байгууллагаас гаргасан системийн хэмжээнд дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэдэг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулан мөрддөг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглаж, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 211,759.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,176.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 2,382.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	8,432.18	3,430.21	(5,001.98)
Бараа материал	9,013.82	10,908.29	1,894.47
Үндсэн хөрөнгө	62,067.48	61,652.08	(415.40)
Нийт хөрөнгө	79,513.48	75,990.57	(3,522.90)
Өр төлбөр	1,044.50	748.00	(296.50)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	78,468.98	75,242.57	(3,226.40)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	79,513.48	75,990.57	(3,522.90)

Авлага дансны үлдэгдэл 5,001.98 мянган төгрөгөөр буурсан нь бусад байгууллагаас авах авлагыг барагдуулсантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,894.47 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 415.40 мянган төгрөгөөр буурсан нь 12,729.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн 13,144.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,226.40 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 187,820.4 мянган төгрөгөөр, өөрийн орлогоор 35,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 222,820.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 187,820.4 мянган төгрөгийн, өөрийн орлогоор 36,191.5 мянган төгрөгийн, урд оны давсан орлогоос 9,604.0 мянган төгрөг нийт 233,615.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 229,717.7 мянган төгрөгийг зарцуулж, 3,898.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дээд шатны байгууллагын шийдвэрээр 12,729.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь ЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь тооллогын бүртгэлийн үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, эд хариуцагч болон жолоочтой тооцоо бодож хэвшээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 147 мэдээ байршуулахаас 4 мэдээ хугацаа хоцроож, цалингаас бусад 5 саяас дээш үнийн дүтэй мэдээг буруу мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна..

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодогч В.Золжаргалын эзэмшилд байсан 2,000.0 мянган төгрөгийн өртөгтэй зөөврийн компьютер ажил хүлээлцэх үед дутагдсан гэх тайлангийн дараах үйл явцын шийдвэрлэлтийг шалгах

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Засварын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 8,401.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 748.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 349.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,986.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,317.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 473.0 мянган төгрөгийн, үр дүнгийн тайланд 275.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

4.2.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

- ✓ *Ажилианд 349.9 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны болон ур чадварын нэмэгдлийг илүү тооцоолж олгосон.*

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ *Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.3 заалтыг үндэслэн илүү олгосон нэмэгдэл хөлсийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.*

4.2.3 Албан шаардлага

1.1. Илрүүлэлт:

- ✓ *Жилийн эцсийн тооллогын бүртгэлийн дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй.*

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.1.2 заалтыг үндэслэн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлээ.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.3. Илрүүлэлт:

- ✓ 1,317.1 мянган төгрөгийн зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй;

1.4. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Завхан аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс	5	8.4	2	0.7	1	0.4	1	6.0	1	1.3
Дүн		5	8.4	2	0.7	1	0.4	1	6.0	1	1.3